

СҮХБААТАР АЙМГИЙН ДАРЬГАНГА СУМЫН
ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР

2022 оны 09 дүгээр сарын мэдээлэл

2022.09.23.

“Овоот”

Нэг. ТӨРИЙН УДИРДЛАГЫН ЧИГЛЭЛЭЭР.

-Сумын Иргэдийн Төлөөлөгчдийн ээлжит X хуралдаанаар дараах асуудлыг хэлэлцэн шийдвэрлэв. Үүнд:

а/. 2023 оны газар зохион байгуулалтын өмчлөлийн төлөвлөгөө батлах тухай

б/. Газрын дуудлага худалдааны орлогыг төвлөрүүлэх, зарцуулах, тайлагнах журам

в/. Газарзүйн нэр тодруулалтын ажлын тайлан хэлэлцэх тухай

ИТХ-ын ажлын албанаас : Улс төрийн хилс хэрэгт хэлмэгдэгчдийг санан дурсах, тэдний дурсгалыг мөнхжүүлэх 27 дахь өдрийг тэмдэглэн өнгөрүүлэх үйл ажиллагааны хүрээнд сумын ЕБС-тай хамтран 8-12 дугаар ангийн 60 гаруй хүүхдүүдийн дунд **"Монголд өрнөсөн улс төрийн хэлмэгдүүлэлт, дүгнэлт, сургамж"** сэдвээр сургалтыг зохион байгууллаа. Мөн сурагчдын дунд танин мэдэхүйн "АХА" тэмцээнийг зохион байгуулан 3 хүүхдийг шагнаж урамшуулсан.

-Хууль эрх зүйн сургалт, сурталчилгааны ажлын чиглэлээр

Хөдөөгийн 4 багийн өдөрлөгийг 2022.09.15 наас 18 ны өдрүүдэд зохион байгуулж, сумын ИТХ, сумын Засаг дарга, Тамгын газрын мэргэжилтэнгүүд цаг үеийн мэдээлэл хийж, иргэд малчидтай харилцан ярилцаж, санал хүсэлтийг хүлээн авлаа. Үүнд:

а/. Хөдөлмөрийн тухай хуулийн (70,1 буюу туслах малчны гэрээ байгуулах), Ерөнхийлөгчийн 2022 оны 43 дугаар зарлиг (Архидалтгүй нийгмийн төлөө), Оюутны сургалтын төлбөрийн хөнгөлөлт, зээлийн сангийн талаар мэдээлэл өгч “АРХИАР ДАЙЛАХГҮЙ” анхны сум уриалгыг тараалаа.

б/. Нийгмийн даатгал

в/. Хөдөлмөр, нийгмийн халамжийн чиглэлээр

г/. Татвар төлөлтийн талаар тус тус сурталчилгаа мэдээлэл сургалтыг зохион байгууллаа. Нийт 4 багийн 480 иргэн хамрагдлаа.

Хоёр. ХӨДӨӨ АЖ АХУЙН ЧИГЛЭЛЭЭР

Хөдөө аж ахуйн өвөлжилтийн бэлтгэл ажлын хүрээнд төлөвлөгөө боловсруулан, Аюулгүй нөөцөд 100 тн өвс, 30 тн тэжээл бэлтгэнэ. Хадлан бэлтгэлд 8 салаа гарч, 280 тн өвс бэлтгээд байгаа. 83914 эх мал төллөж, төл бойжилт 75 %- тай байна.

Хилийн зурваст 44 өрхийн 25315 мал, гадна суманд 14 өрхийн 11125 мал өвөлжинө.

Төв суурингийн өвөлжилт хаваржилтын бэлтгэл ажил хангагдаж “Одкон Холдинг” ХХТ-тай хамтран ташуу байрлалтай 3 янданг босгож, уурын зууханд сэнс тавьж, яндангаа хөөлөх зэрэг ажлыг хийж, “Андын элс” ХХК-тай нүүрсний гэрээг байгуулаад нүүрс татан авалтыг эхлүүлээд байна.

Бруцеллёзын тарилгыг 49.200 мянган толгой малд тарьж, тарилга 84,9%-тай хийгдээд байна. Малчдын хүчээр мал угаалгын 2 ванныг гар аргаар шинээр барьж ашиглалтад оруулан бог малыг угаалганд хамрууллаа.

Гурав. СОЁЛ, БОЛОВСРОЛЫН ЧИГЛЭЛЭЭР

9 р сарын 01 ний өдөр Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2022.07.11-ний өдрийн 159 дүгээр зарлигийн дагуу "Их Эзэн Богд Чингис" хааны эш хөргийг дээдлэн заллаа.

Цэцэрлэг: 2022-2023 оны хичээлийн жилд 2-5 насны нийт 220 хүүхдийг 85% тай танхимаар 190, хувилбарт сургалтанд 30 хүүхэд суралцаж байна.

Орон нутгийн төсвийн 20 сая төгрөгийн санхүүжилтээр гадна эко модон тоглоомыг бий болгосон. Хүүхэд хамгааллын ажлыг эрчимжүүлж ГХУСэргийлэх ажлын хүрээнд Цэцэрлэгийн 6 бүлэгт камержуулалт хийгдлээ. Сургалтын болон аж ахуйн бэлэн байдлыг ханган гадна талын засвар, гэрэлтүүлэг, цэвэрлэгээ ариутгал халдваргүйжүүлэлт хийж нийт 3 сая төгрөг зарцуулсан.

Цэцэрлэг, Соёлын төвд 5 сая төгрөгийн санхүүжилтээр компьютерын тоног төхөөрөмжтэй олгов.

Сургууль: 590 суралцагч, 54 багш ажилтантай шинэ хичээлийн жилийг эхлүүлж, 2 ангид ОНХС-ийн 10 сая төгрөгийн санхүүжилтээр ширээ сандалтай болгосон. Дарьганга сумын анхны бага сургуулийг байгуулахад анхны захирлаар ажиллаж байсан Ч.Аварзэдийн охин А.Дашням, А.Дашбат мөн Дарьганга сумын уугуул бэлтгэл хурандаа Сэрээтэрийн Цэдэндамбаа гуай нарын зүгээс ЕБС-ийн Мэдээлэл зүйн кабинетэд хичээлийн үзүүлэн, хэрэглэгдэхүүн, Биеийн тамирын багш, сурагчдад зориулан Олимп судлалын танхим болон цэрэг эх орны сэдэвт "Дайчин алдрын булан" зэргийг тохижуулж оюуны үнэтэй хөрөнгө оруулалт хийлээ.

Дөрөв. Эрүүл мэндийн чиглэлээр

ЭМТ, Хүүхдийн цэцэрлэг хамтран сувилалын цэцэрлэгт нийт 2-5 насны 30 хүүхдийг хамруулж, сургалт үйл ажиллагаа болон шар ус, сүү, айраг, шар тосон иллэг массаж, шарлаг эмчилгээ хийж, эцэг эхчүүдэд зөвлөгөө зөвлөмж өгч 14 хоногийн сургалтыг зохион байгуулсан.

Зургаа: Байгаль орчны чиглэлээр.

- Байгаль орчин аялал жуулчлалын яамны сайдын 2022 оны 09 дүгээр албан даалгаврын хэрэгжилтийг хангаж, усны нөөцийг бохирдол хомсдлоос хамгаалах зорилгоор уст цэгийн орчинд их цэвэрлэгээ хийх ажлыг үе шаттай зохион байгуулж зүүн голын орчныг цэвэрлэн 3 тн хогийг түүж нэгдсэн цэгт төвлөрүүлээ.

- Золбин нохой устгалын 2 дахь удаагийн ажиллагааг зохион байгуулж байна.

- Нэгдсэн хогийн цэгийг 9 дүгээр сард 3 удаа түрж цэгцлэн, лантифелдах аргаар булж янзлах ажлыг хийж эхлүүлээд байна. Мөн их цэвэрлэгээний ажилд “Нийтийг хамарсан ажил” төслийн хүрээнд ажилгүй 10 иргэнийг аймгийн ХХҮГ-ын 5 сая төгрөгийн санхүүжилтээр цалинжуулан ажиллуулж байна.

-“ЯНДАНГАА ХӨӨЛЪЕ-ӨНТЭЙ ӨВӨЛЖЪЕ” , “МОДОО ТӨГӨЛ-ХОГОО МӨНГӨ БОЛГОЁ” аянуудад нэгдээд ажиллаж байна.

-Тэрбум мод үндэсний хөдөлгөөний хүрээнд “Ногоон сум” төсөл хэрэгжүүлж байгаа бөгөөд одоогоор 8000 мод тарьж ургалт 90 % тай, намрын мод тарилтын ажлыг эхлүүлэх бэлтгэл хангагдаад байна. Мөн төслийн хүрээнд 1500000 төгрөгийн өртөг бүхий сурталчилгааны самбар байршуулсан.

-2022.09.23 ны өдөр БОАЖЯ-ны ажлын хэсэг Ганга нуурын орчны улсын төсвийн хөрөнгөөр хийгдэж буй ажилтай танилцах зэрэг бусад ажлаар суманд БЦГХЗ-тай хамтран ажиллаж байна.

МЭДЭЭЛЭЛ БИЧСЭН

МЭРГЭЖИЛТЭН

Д. МӨНХЗУЛ

ТАНИЛЦСАН

ЗАСАГ ДАРГА

Д. БОЛДБААТАР